

АЖЛЫН ДААЛГАВАР

| | |
|----------------------|--|
| Төслийн нэр | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нэгдсэн төсөл |
| Байршил | Монгол Улс, Улаанбаатар |
| Ажлын даалгаврын нэр | Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бодлогын стратеги боловсруулах ахлах зөвлөх |
| Үйлчилгээний нэр | Албан эдийн засагт шилжилтийн цогц бодлогын стратеги, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах |
| Гэрээний төрөл | Зөвлөх үйлчилгээ |
| Хэлний мэдлэг: | Монгол, Англи хэл |
| Гэрээний хугацаа: | 2026.06.01-2026.10.30 (5 сар) |

ҮНДЭСЛЭЛ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ) нь Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банкны санхүүжилтээр “Салбарын Нэгдсэн төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Дэлхийн банкны Олон Улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй хүргэх, онцгой байдлын үед шаардлага хангасан ажиллагчдад түр хугацааны дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэгжүүлж байна.

Төсөл нь дараах 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

- 1) Одоогийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тогтолцоог цогц байдлаар шинэчлэн ажил хайгч болон ажил олгогч нарт “үйлчлүүлэгч-төвтэй” үйлчилгээг хувийн зуучлалын байгууллагуудтай хамтран хүртээмжтэй хүргэх;
- 2) Сонгогдсон хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлтэд нийцсэн байдлыг бэхжүүлэх;
- 3) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээний чанар, хүртээмжийг сайжруулснаар байгууллага болон хувь харилцагчид мэдээлэлтэй шийдвэр гаргахад нь туслах, төслийн менежмент, хяналт шинжилгээ, үнэлгээнд дэмжлэг үзүүлэх,
- 4) Бизнес эрхлэгчид болон ажилтнуудад цар тахлын үзүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зохих шалгуур хангасан ажиллагчид болон ажил олгогчдод богино хугацааны тэтгэмж олгох бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Төслийн 1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд албан бус хөдөлмөр эрхлэлтийн бодлогын стратеги боловсруулахаар төлөвлөж байна. Энэ ажил нь МУ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын 8.3, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 3.3 зорилтууд болон ГБХНХЯ-ны албан бусаас албан эдийн засагт шилжих бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулна.

Албан бус сектор, албан бус хөдөлмөр эрхлэлт нь хөгжиж буй болон хөгжингүй орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн чухал сорилтын нэг юм. Хөгжиж буй бусад орнуудын нэгэн адил, Монгол Улсын эдийн засаг, ДНБ болон хөдөлмөрийн зах зээлд албан бус сектор, албан бус ажил эрхлэлт чухал нөлөөтэй байна.

Дэлхийн банкны санхүүжилттэй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлт”-ийн төслийн хүрээнд 2024 онд албан бус сектор, албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар хийгдсэн судалгаа, тоон мэдээлэл, статистик шинжилгээ, хуулт эрх зүйн орчин, бодлогын хэрэгжилтийн талаар суурь судалгааг¹ хийсэн. Судалгаанаас үзэхэд 2019-2023 оны хооронд 5 жилийн дунджаар улсын хэмжээнд нийт албан бус ажил эрхлэгчдийн 58%-ийг ХАА-н салбарт ажиллагсад, 42%-ийн ХАА-н бус салбарт ажиллагсад бүрдүүлж байна.

2023 оны байдлаар улсын хэмжээнд нийт 1,215,835 ажиллагчдын 293,757 нь буюу 24 хувь нь ХАА-н салбарт ажиллаж байна. Харин нийт ажиллагсдын 76 хувь буюу 922,078 нь ХААБС салбарт ажиллаж тэдгээрийн 199,147 буюу 22 хувь нь албан бус ажиллагч байна. Нийт салбарын хувьд авч үзвэл нийт ажиллагсдын 472,877 буюу 39 хувь нь албан бус хөдөлмөр эрхэлж байна. ХАА-н бус салбарт албан

¹ Дэлхийн банкны санхүүжилттэй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийн хүрээнд 2024 онд AFIM Mongolia ТББ-ын хийсэн албан бус сектор, албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар суурь судалгаа.

бус хөдөлмөр эрхлэгчдийг эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар авч үзэхэд, үйлчилгээний салбарт 65 хувь, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарт 35 хувь нь ажиллаж байна.

Уул уурхайн салбарын албан бус ажил эрхлэгчдийн түвшин 2019 оноос 2023 оны хооронд 14 хувиас 2 хувь хүртэл буурсан байна. Мөн адил Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын албан бус хөдөлмөр эрхлэгчийн түвшин 2019-2023 онд 25 хувиас 9 хувь болж буурсан. Харин Урлаг үзвэр, тоглоом наадмын салбарын тус үзүүлэлт 2019 онд 9 хувь байсан нь 2023 онд 20 хувьд хүрч өссөн.

2023 оны байдлаар ХААБС-т албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 63 хувь нь үйлчилгээний салбарт, 37 хувь нь аж үйлдвэр, барилгын салбарт ажиллаж байна. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хамгийн олон нь буюу 27 нь хувь бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг бол 18 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 17 хувь нь барилгын салбар, 15 хувь нь тээвэр, агуулахын салбарт ажиллаж байна.

Албан бус сектор ба албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх Монгол Улсын хууль, эрх зүйн орчин, зохицуулалт

Монгол Улсад бизнесийн үйл ажиллагаа болон хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид албан бус сектор, албан бус хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулсан нарийвчилсан зүйл, заалт байхгүй ч албан бус сектор, албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх заалтууд хууль тогтоомжид тусгагдсан байна. Дэлхийн олон улс оронд албан бус хөдөлмөр эрхлэлтийг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэх үзүүлэлтийг ашиглан тооцдог. Монгол улс ч гэсэн албан бус хөдөлмөр эрхлэлтийг тодорхойлохдоо тус үзүүлэлтийг ашигладаг. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.1-д “Нийгмийн даатгал нь албан журмаар болон сайн дураар даатгуулах гэсэн хэлбэртэй байна” гэж заасан. Энэ заалт нь албан бус сектор болон албан бус хөдөлмөр эрхлэгч, иргэд сайн дураар даатгуулах сонголтод илүү хамаатай бөгөөд төрөөс үзүүлэх хөнгөлөлт, урамшуулал, нийгмийн хамгаалал, банкны зээлд хамрагдах зэрэг хэрэгцээ, шаардлагаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр өөрийн санаачилгаараа даатгуулж болох боломжийг бүрдүүлсэн байдаг.

Албан бус хөдөлмөр эрхлэгчид нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, эрүүл мэнд, аюулгүй байдлын зохицуулалт, нийгмийн хамгааллын тэтгэмж зэрэг албан ажиллагсад олгодог хууль эрх зүйн хамгаалалтад хамрагдаж чаддаггүйгээс тэдний орлого тогтворгүй, хөдөлмөрийн нөхцөл тааруу, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, нийгмийн хамгаалал хязгаарлагдмал байна.

Монгол Улсад албан бус хөдөлмөр эрхлэлт нь нийт хөдөлмөр эрхлэлтийн томоохон хувийг эзэлж байгаа бөгөөд ажиллагчдын нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн нөхцөл, орлогын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Иймээс албан бусаас албан эдийн засагт шилжилтийг дэмжих, албан бус хөдөлмөр эрхлэлтийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх бодлогын стратегийг боловсруулах шаардлагатай байна.

Төслийн хүрээнд Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх олон улсын жишигт нийцсэн тодорхойлолт, хэмжилтийн арга зүй, 2019–2023 оны Ажиллах хүчний судалгааны мэдээлэлд суурилсан статистик дүн шинжилгээ, түүнчлэн холбогдох хууль эрх зүй, бодлогын зохицуулалтын талаар суурь судалгааг хийсэн. Мөн албан бус хөдөлмөр эрхлэгчдийн онцлогийг салбар, хөдөлмөр эрхлэлтийн байдал, орлого, хөдөлмөрийн нөхцөл, хүн ам зүйн хүчин зүйлээр нь шинжилж, албан ёсны хөдөлмөр эрхлэлтийн боломж хязгаарлагдмал байдал, зохицуулалт болон татварын дарамт, үр чадварын үл нийцэл зэрэг албан бус хөдөлмөр эрхлэлтийг бий болгож буй гол хүчин зүйлсийг тодорхойлсон. Судалгаа нь суурь мэдээллийг бүрдүүлсэн хэдий ч хэд хэдэн асуудал цаашид нарийвчлан судлах шаардлагатай хэвээр байна. Үүнд салбар болон бүс нутгийн түвшин дэх албан бус хөдөлмөр эрхлэлтийн суурь хүчин зүйлсийн талаарх гүнзгийрүүлсэн шинжилгээ хязгаарлагдмал, одоо хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрүүдийн үр нөлөөний үнэлгээ хангалтгүй, мөн хэрэгжүүлэх тодорхой механизм, эрэмбэлсэн тэргүүлэх чиглэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүхий цогц бөгөөд хэрэгжүүлэх боломжтой бодлогын стратеги дутмаг байна. Түүнчлэн, судалгааны үр дүнг албан ёсны эдийн засагт шилжих үйл явцыг дэмжих бодлогын тодорхой хувилбарууд болон институцийн зохицуулалтын арга хэмжээнд тусган боловсруулах чиглэлээр цаашид ажиллах шаардлагатай байна.

Иймд ГБХНХЯ албан бус хөдөлмөр эрхлэлтийн үндэсний бодлогын стратегийг боловсруулах ажлыг удирдан зохион байгуулж, бодлогын чиглэл, стратегийн хүрээ, хэрэгжилтийн механизмыг боловсруулах ахлах зөвлөх ажиллуулахаар төлөвлөж байна. Энэхүү ажлын даалгавар нь албан эдийн

засагт шилжилтийг хэрэгжүүлэх бодлогын стратеги, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ахлах зөвлөхийн гүйцэтгэх ажлын цар хүрээ болон нийлүүлэх бүтээгдэхүүнийг тодорхойлно.

ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Ажлын зорилго:

Албан бус хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдал болон холбогдох хууль, эрх зүйн орчинд хийсэн өмнөх судалгаанд² үндэслэн ахлах зөвлөх нь нэмэлт дүн шинжилгээ хийж, албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, албан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бодлогын стратеги, стратегийн төлөвлөгөөг боловсруулна.

Ажлын хүрээ:

Ахлах зөвлөх нь албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, албан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогын стратегийг боловсруулах ажлын хүрээнд дараах үндсэн ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх өмнөх судалгаанд тодорхойлсон цоорхойг нөхөх зорилгоор албан бус байдлын суурь шалтгаан, хүчин зүйлсэд гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийж, одоо хэрэгжиж буй бодлого, арга хэмжээний үр нөлөөг үнэлэх;
- Стратеги боловсруулах үйл явцад оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, удирдан чиглүүлэх;
- Албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, албан ёсны хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн цогц бөгөөд хэрэгжүүлэх боломжтой бодлогын стратегийн баримт бичгийг боловсруулах;
- Тэргүүлэх чиглэл, институцийн зохицуулалт, хэрэгжүүлэх механизм, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог тодорхойлсон стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах;

Гүйцэтгэх ажлууд: Зөвлөх нь нь дараах ажлуудыг гүйцэтгэнэ:

- 1. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн суурь шалтгаан, хүчин зүйлсийг судалж, хэрэгжиж буй бодлого, арга хэмжээний үр нөлөөг үнэлэх;**
 - Салбар болон бүс нутгийн түвшин дэх албан бус хөдөлмөр эрхлэлтийн суурь шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлсийг, түүнчлэн хүн амын ялгаатай бүлгүүдэд тулгарч буй онцлог бэрхшээл, хэрэгцээг системтэйгээр судлах;
 - Албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан хэлбэрт шилжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдийн үр нөлөө, хэрэгжилтийг үнэлэх;
 - Дундаас дээш орлоготой орнуудад хэрэгжүүлсэн албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээрх амжилттай бодлого, стратегийн харьцуулсан судалгаа хийж, албан бус байдлыг зохицуулах болон албан хэлбэрт шилжих үйл явцыг дэмжих татварын бодлого, бизнесийн зохицуулалт, нийгмийн даатгалын тогтолцоо, захиргааны журмуудад дүн шинжилгээ хийх;
- 2. Оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн системчлэх;**
 - Хэлэлцүүлгийн хүрээнд техникийн санал, зөвлөмж авах, салбарын онцлогтой холбоотой тулгамдсан асуудлыг тодорхойлох, хот, хөдөө болон бүс нутгийн ялгаатай нөхцөл байдлыг үнэлэх, мөн хувийн хэвшил, ажил олгогчдын оролцоог хангах зорилгоор уулзалтууд зохион байгуулна.
 - Татвар, нийгмийн даатгал, аж ахуйн нэгжийн бүртгэлийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд, ажил олгогчид, албан бус эдийн засгийн нэгжүүд, ажилчид зэрэг холбогдох оролцогч талуудтай хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулж, удирдан чиглүүлэх;
 - Хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтаас гарсан санал, зөвлөмжийг нэгтгэж оролцогч талуудын дүгнэлт, саналыг стратегийн баримт бичгийн төсөлд тусгах;
- 3. Албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах бодлогын стратегийн төслийг боловсруулах;**

² Гэрээний хүрээнд AFIM Mongolia ТББ нь 2024 онд албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг хийж, холбогдох хууль эрх зүй болон бодлогын орчны өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн. Тус судалгаанд Үндэсний статистикийн хорооны Ажиллах хүчний судалгаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээний судалгааны институтын Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх судалгаа, мөн бусад холбогдох судалгаа, мэдээллийн эх сурвалжуудыг ашигласан болно.

- Судалгаа, шинжилгээ болон оролцогч талуудын санал, зөвлөмжид үндэслэн албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, албан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр стратегийн зорилго, зорилтуудыг тодорхойлох;
- Холбогдох бодлогын хүрээнд хэрэгжүүлэх стратегийг тодорхойлж, шаардлагатай бол бодлогын өөрчлөлт болон санал санаачилгыг багтаах. Үүнд:
 - Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ;
 - Татвар, нийгмийн даатгал төлөх процедур, төлбөрийн систем;
 - Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа болон албан бус ажил олгогчдыг албажуулах;
 - Төрийн үйлчилгээ, хөтөлбөр, үр чадвар хөгжүүлэх сургалт, жижиг зээл болон төрийн худалдан авалтын хүртээмжийг нэмэгдүүлэх;
 - Албан бус ажилтныг ажилд авах, албажуулсан ажил олгогчид олгох урамшуулал;
 - Хууль хэрэгжилтийг хангах стратеги, арга хэмжээ;

4. Бодлогын стратеги хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах

- Стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн богино, дунд, хугацааны арга хэмжээг тодорхойлох;
- Стратегийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах институцийн зохицуулалт болон хэрэгжүүлэх механизмыг тодорхойлох;
- Стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн боломж, эх үүсвэрийг тодорхойлох;
- Хэрэгжилтийн явцыг үнэлэх хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах.

5. Бодлогын стратегийн баримт бичгийг эцэслэн боловсруулах

- Бодлогын стратегийн баримт бичгийг боловсруулж, бодлогын чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээ, институцийн зохицуулалт, мөн үр дүнтэй хэрэгжилтийг хангах хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог тусган эцэслэн боловсруулах;
- Бодлогын үндсэн чиглэл, санал, зөвлөмжийг нэгтгэн тусгасан стратегийн баримт бичгийн PowerPoint танилцуулгыг бэлтгэх;

Стратеги төлөвлөгөөг боловсруулахад 2015 онд ОУХБ-аас гишүүн орнуудад зөвлөмж болгосон Албан бус салбараас албан эдийн засагт шилжих шилжилтийн зөвлөмж, зааварчилгааг анхаарч үзнэ.

Дараах судалгааны тайлан болон бусад холбогдох материалыг ашиглана:

-Ажиллах хүчний судалгаа (ҮСХ)

-Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн төлөв байдал (ОУХБ, ХНХСҮСИ)

<https://www.social-protection.org/gimi/Course.action?id=3>

-Албан бус эдийн засагт ажиллагчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлэх (ОУХБ)

https://www.ilo.org/beijing/what-we-do/publications/WCMS_834558/lang--en/index.htm

-Сүүдрийн эдийн засгийн судалгаа ба тооцоолол, 2015-2018 (ҮСХ)

http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=NOE_2015-2018.pdf&ln=Mn.

- Дэлхийн банкны санхүүжилттэй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийн хүрээнд 2024 онд AFIM Mongolia ТББ-ын хийсэн албан бус сектор, албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар суурь судалгаа

-Дэлхийн банкны “Албан бус байдлын үрт сүүдэр: Сорилт ба бодлого” тайлан, 2022.

The Long Shadow of Informality: Challenges and Policies

-Дэлхийн банкнаас ГБХНХЯ-ны Нийгмийн даатгалын бодлогын газрын багт танилцуулсан албан бус хөдөлмөр эрхлэгчдэд нийгмийн хамгааллыг хүртээмжтэй болгох талаарх PowerPoint танилцуулгын слайдууд;

-Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Албан бус эдийн засаг дахь ажиллагчдад нийгмийн хамгааллыг хүртээмжтэй болгох нь: Олон улсын туршлагаас суралцах нь” тайлан, 2022;

-Монгол дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийн байдал, ОУХБ, 2021.
<https://www.ilo.org/publications/state-informal-employment-mongolia-survey-report>

- Сүүлийн үеийн бусад холбогдох тайлан.

Нийлүүлэх бүтээгдэхүүн:

Ахлах зөвлөх нь дараах бүтээгдэхүүнийг нийлүүлнэ: Ажлын аргачлал болон ажлын төлөвлөгөөг 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн дотор ГБХНХЯ-нд хүргүүлж, баталгаажуулсан байна.

Бүтээгдэхүүн 1. 2026 оны 06 дугаар сарын 30-ны дотор:

- 1.1 Албан бус хөдөлмөр эрхлэлтийн суурь шалтгаан, хүчин зүйлсийг салбар, бүс нутаг болон хүн амын бүлгээр ангилан судалсан аналитик судалгааны тайлан;
- 1.2 Албан бус хөдөлмөр эрхлэлт нэмэгдүүлж буй болон бууруулахад чиглэсэн одоогийн бодлого, хөтөлбөрүүдэд хийсэн дүн шинжилгээний тайлан;
- 1.3 Дундаас дээш орлоготой орнуудад хэрэгжүүлсэн албан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх стратегийн харьцуулсан судалгаа.

Бүтээгдэхүүн 2. 2026 оны 08 дугаар сарын 31-ний дотор:

- 2.1 Хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтын тайлангууд;
- 2.2 Стратегийн зорилго, зорилтууд болон бодлогын хувилбаруудыг тодорхойлсон бодлогын стратегийн баримт бичгийн төсөл;
- 2.3 Хэрэгжүүлэх арга хэмжээ, санхүүжилтийн стратеги, институцийн зохицуулалт, хэрэгжилтийн механизм болон хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог тодорхойлсон бодлогын стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл.

Бүтээгдэхүүн 3. 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор:

- 3.1 Эцсийн стратегийн баримт бичиг. (i) Бодлогын стратеги (ii) Стратегийн хэрэгжилтийн төлөвлөгөө (ГБХНХЯ-аар хянуулан, санал зөвлөмжийг тусгаж эцэслэсэн байна);
- 3.2 Дээрх бүтээгдэхүүнүүдийн PowerPoint танилцуулга.

Гэрээний хугацаа:

Зөвлөх нь уг ажлыг нийт ажлын 5 сарын хугацаанд буюу 2026.06.01-ээс 2026.10.30-ны хооронд гүйцэтгэнэ. Гэрээг сунгах боломжгүй.

Гэрээний үнэ:

Гэрээний үнийн дүн нь зөвлөхтэй тохиролцсон тогтсон дүн байна. Гэрээний нийт үнийн дүн **60,000,000** төгрөг байх бөгөөд ажлын даалгаварт заасан ажлуудыг гүйцэтгэхэд шаардагдах бүх зардлууд багтсан байна.

Мониторинг, явцын хяналт, тайлагналтад тавигдах шаардлагууд:

Зөвлөх нь дээр дурдсан ажлыг ГБХНХЯ болон НТХН-ийн удирдамж, хяналтын дор гүйцэтгэнэ. Зөвлөхийн ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

- 6. Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал;
- 7. Төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал;
- 8. Гүйцэтгэсэн ажлын чанар.

Тайлагналт:

Зөвлөх нь ГБХНХЯ болон НТХН-д ажлаа тайлагнаж ажиллана. Зөвлөх нь гэрээний төлбөрийн хуваарьт заасан төлбөр авахын өмнө ГБХНХЯ болон НТХН-д Бүтээгдэхүүн хүлээж авах маягыг бөглөж ирүүлнэ.

Төлбөрийн хуваарь:

Гэрээний үнийн дүн нь энд заасан хугацааг сунгасан эсэхийг үл харгалзан үр дүнд суурилсан тогтсон дүн байна. Гэрээний төлбөрийг дараах хуваарийн дагуу төлнө:

| Бүтээгдэхүүн | Төлбөр |
|------------------------------|---------------------------------------|
| Бүтээгдэхүүн 1.1 ба 1.2, 1.3 | Зөвлөх үйлчилгээний ажлын хөлсний 30% |
| Бүтээгдэхүүн 2.1; 2.2 ба 2.3 | Зөвлөх үйлчилгээний ажлын хөлсний 30% |
| Бүтээгдэхүүн 3.1; 3.2 | Зөвлөх үйлчилгээний ажлын хөлсний 40% |

Зөвлөхийн нийлүүлсэн бүтээгдэхүүнийг ГБХНХЯ/НТХН хүлээн авсны дараа төлбөрийг олгоно.

ШААРДЛАГАТАЙ УР ЧАДВАР, АЖЛЫН ТУРШЛАГА

Зөвлөх нь дараах шаардлагыг хангасан байна:

Боловсрол:

- Эдийн засаг, хөдөлмөрийн эдийн засаг, нийгмийн хамгаалал, төрийн удирдлага, хөгжлийн судалгаа, эсхүл холбогдох чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
- Докторын зэрэгтэй бол давуу тал болно.

Туршлага:

- Эдийн засаг, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн хамгаалал, хөгжлийн бодлого зэрэг холбогдох чиглэлээр 10-аас дээш жил ажилласан байх;
- Хөдөлмөр эрхлэлт, ялангуяа албан бус хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн бодлого, нийгмийн хамгааллын тогтолцооны судалгаа, дүн шинжилгээ хийх чиглэлээр ажиллаж байсан 5-аас доошгүй ажлын туршлагатай байх;
- Үндэсний болон салбарын түвшний бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах зэрэг ажилд ажиллаж байсан 5-аас доошгүй жилийн туршлагатай байх;
- Төрийн байгууллага, олон улсын байгууллага (Дэлхийн банк, Олон улсын хөдөлмөрийн байгууллага) болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно;
- Томоохон хэмжээний судалгаа, зөвлөх үйлчилгээ, төсөл хөтөлбөрийг удирдан зохион байгуулж байсан туршлагатай бол давуу тал болно.

Ур чадвар:

- Бодлогын дүн шинжилгээ хийх, стратеги төлөвлөх өндөр чадвартай;
- Оролцогч талуудтай үр дүнтэй харилцах, зөвшилцөл бий болгох ур чадвартай;
- Тайлан, бодлогын баримт бичгийг товч, ойлгомжтой, мэргэжлийн түвшинд бичих чадвартай;
- Харилцааны өндөр ур чадвартай, зохион байгуулалттай;
- Англи хэлний ярианы болон бичгийн өндөр түвшний мэдлэгтэй;
- Багаар ажиллах, асуудлыг цогцоор зохицуулах ур чадвартай.